



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН
ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ”-Д ХИЙСЭН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ДУА-2023/25-10-ШТА-ГА/

Дундговь дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Батсайхан

Аудитор Б.Гантуяа Утас: 7059-2208,

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-6
	Дүрслэлийн товъёг	7
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>Бүлэг А. Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хөрөнгийн ашиглалт, хэрэгжилт үр дүнтэй ч гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж ажиглаагүй байна.</u>	8
Аудитын менежер	А.2Зээлийн хөрөнгийг ашиглагч гэрээнд заасан үүргээ тогтоосон хугацаанд бүрэн биелүүлсэн байна.	8
Х.Наранцацрал	<u>Бүлэг Б. Хөдөө аж, ахуйн салбарт хрэгжүүлсэн тусламж олон нийтийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа боловч зарим хөрөнгийг зориулалтын ашиглаагүй, үр дүнг тооцож ажиглаагүй байна.</u>	9
Ахлах аудитор Т.Батсайхан	Б.1.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь урт, дунд, богино хугацааны бодлогыг дэмжиж байна.	9
Аудитор Б.Гантуяа	Б.1.2. Аймгийн хэмжээнд хөдөө аж, ахуйн салбарт хэрэгжсэн тусламж нь тус салбарт шаардлагатай хөрөнгүүд нийлүүлэгдсэн байна.	9-10
	Б.2.1. Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдэх тоног,төхөөрөмжийн хугацаа 56 хоногоор хэтэрсэн байна.	10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	Б.2.2. Гэрээний биелэлтийг дүгнэж, хэрэгжилтийг тооцоогүй байна..	11
ХАЯГ:	<u>Бүлэг В Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавьсан ч, бүрэн баримтжуулаагүй, санхүүгийн бүртгэл зөрүүтэй байна.</u>	11
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 209 тоот	В.1Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавих хяналт үр дүнтэй байна.	11
	В.1.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээнд эрх бүхий байгууллагууд хяналт тавьсан ч бүрэн баримтжуулаагүй байна.	12
2023 оны 8 дугаар сар	В.2. Зээл, тусламжийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцоогүй байна.	12
	В.2.1. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.	12-13
	В.2.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний бүртгэл зөрүүтэй байна.	13-14
	Дүгнэлт	15
	Зөвлөмж	16
	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	16
	Тайлангийн хавсралтууд	17



Тайлан баталгаажуулах тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/96

Мандалговь

Аудитын тайланг баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан / ДУА-2023/25-10-ШТА-ГА / -г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (албан шаардлага) –ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

1. “Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2023 оны 12 дугаар сарын 20-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/, аймгийн ЗДТГ-ын дарга /Л.Доржбат/ нарт зөвлөсүгэй.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2023 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг Аудитын гуравдугаар нэгжийн ахлах аудитор /Т.Батсайхан/ аудитор /Б.Гантуяа/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг дарга
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МАЗЭЭН	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх
ТАХ	Төсөл, арга хэмжээ
УИХ	Улсын их хурал
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААХҮ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

<i>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</i>	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/04 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Хөдөө аж, ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-д Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийлээ
<i>Аудитын зорилт:</i>	“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн Үүнд: ✓ Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх, ✓ Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх, ✓ Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх.
<i>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:</i>	Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. ✓ “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол), ✓ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай (УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол), ✓ Төсвийн тухай хууль, ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ✓ Шилэн дансны тухай хууль, ✓ Өрийн удирдлагын тухай хууль, ✓ Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”, ✓ Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга

Аудитын хамарсан хүрээ:

- хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”,
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.
- ✓ Дундговь аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, 2019-2022 оны аймаг хөгжүүлэх төлөвлөгөө;

Аудитад аймгийн Засаг дарга, ЗДТГ, Хүнс хөдөө аж ахуйн газар, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж буй аж ахуй нэгжүүд болон төслийн удирдах хороо, төслийн нэгж, хэрэгжүүлэгч холбогдох байгууллагын үйл ажиллагаа, 2016-2022 оны хугацаан дахь зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр дүнг хамруулна.

Аудитыг Засгийн газрын шугамаар болон хандивлагч орон, олон улсын байгууллагаас хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олгосон гадаад зээл, тусламжийн мэдээ, төслийн нэгжийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангууд, дамжуулан зээлд хамрагдсан аж ахуй нэгж, байгууллагын зээлтэй холбогдох үйл ажиллагааны мэдээлэл, тайлан, бусад нотлох баримт материалд үндэслэн хийнэ.

Шүүхийн шийдвэртэй, хууль хяналтын байгууллагад шалгагдаж буй асуудлыг аудитад хамруулахгүй болно.

Аудитад Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Нэгдсэн үндэсний байгууллагын хөдөө аж ахуйн байгууллагаас 2019-2023 онд санхүүжүүлсэн 8 төсөл, арга хэмжээний хэрэгжилт болон эдгээр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын аудитын стандарт MNS 6817-5:2020, гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

*Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:*

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, аудитын 3-р нэгжийн ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Б.Гантуяа нар 2023 оны 05 дугаар сарын

Аудитын дүн

29-ний өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийг дуустал хугацаанд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитаар нийт 230.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 62.0 сая төгрөгийн дутуу нийлүүлэгдсэн хөрөнгийн зөрчлийг аудитын явцад залруулж, аймгийн Засаг даргад 3 зөвлөмж тус тус хүргүүлээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Дундговь аймгийн Хөдөө аж ахуйн салбарт 2019-2023 онуудад Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Нэгдсэн үндэсний байгууллагын хөдөө аж ахуйн байгууллага, Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн санхүүжилтээр нийт 8 төсөл арга хэмжээнд 6,421.5 сая төгрөгийн тусламж, 2 төсөл арга хэмжээнд 110.0 сая төгрөгийн зээл олгогдсон байна.

Хүснэгтийн товъёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Хүснэгт 1</i>	<i>Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн гэрээний дүн</i>	
<i>Хүснэгт 2</i>	<i>Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн сумдад хуваарилсан байдал</i>	
<i>Хүснэгт 3</i>	<i>Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн арга хэмжээг хуваарилсан байдал</i>	

Хавсралтын товъёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Хавсралт 1</i>	<i>Хөдөө аж, ахуйн салбарт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ</i>	26-28



БҮЛЭГ Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хөрөнгийн ашиглалт, хэрэгжилт үр дүнтэй ч гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж ажиллаагүй байна.

А.2.1. Зээлийн хөрөнгийг ашиглагч гэрээнд заасан үүргээ тогтоосон хугацаанд бүрэн биелүүлсэн байна.

2019-2023 онуудад Дундговь аймгийн Хөдөө аж ахуйн салбарт нийт 110.0 сая төгрөгийн зээл, 6,421.5 сая төгрөгийн тусламж олгогдсон байна.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн хүрээнд Дундговь аймгийн Адаацаг сумын Бага газрын чулуу жуулчны баазад саалийн ямаа авах, цагаан идээ үйлдвэрлэх зориулалтаар 10.0 сая төгрөгийн Төрийн банкны зээлд хамрагджээ. Зээлийг иргэн Түмэндэмбэрэл Цэдэв 2022 оны 04-р сарын 14-ний өдрөөс 2025 оны 04-р сарын 13-ний өдрийг хүртэл 3 жилийн хугацаатай авсан байна. Зээлийн 8.0 сая төгрөгийг батлан даасан одоогийн байдлаар хугацаа хэтэрсэн үлдэгдэлгүй, зориулалтын дагуу зарцуулж, зээлийн хэвийн ангилалд 6.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ зээлийн талаар баримт материал олдоогүй болно.

Харин Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн нэмэлт санхүүжилтээр үйл ажиллагаа өргөжүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн мал нядлагааны үйлдвэр байгуулах зориулалтаар Азтай маамнууд ХХК Төрийн банкнаас эх үүсвэртэй батлан даалттай төслийн 100.0 сая төгрөгийн зээл авч зээлийн эргэн төлөлт хуваарийн дагуу хэвийн төлөгдөж, 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар 65.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Зээлийн эргэн төлөлт, үлдэгдлийн талаар төрийн банкны 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 39-10 тоот албан бичгээр тодорхойлолт ирүүлсэн байна.

Төслийн хүрээнд 2020-2022 онуудад ХХААХҮ-ийн сайд аймгийн Засаг дарга нар орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх, түүний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, гүйцэтгэл, ашиглалт, эзэмшилтэд тавих хяналт, төслийн хэрэгжилтийн тогтвортой байдлыг хангахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахаар хамтран ажиллах гэрээ байгуулжээ. Энэ гэрээнүүдийн хүрээнд нийт 2,831.9 сая төгрөгийн 74 ажлыг гүйцэтгэхээр баталжээ.

Хүснэгт №1

№	Худалдан авалт	Тоо хэмжээ	Нийт төсөвт өртөг	Төслөөс	ОН-аас
1	2020 онд	47	1,227.9	839.3	388.6
2	2021 онд	18	780.0	546.0	234.0
4	2022 онд	9	824.0	412.0	412.0
	Нийт дүн	74	2,831.9	1,797.3	1,034.6

Энэ гэрээнүүдэд төслийн хүрээнд хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтийг аймгийн ЗДТГ бүрэн хариуцан зохион байгуулахаар заажээ. Аймгийн ЗДТГ төслийн ажлын хэрэгжилтийг журмын дагуу зохион байгуулсан ч хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг тооцож баримтжуулаагүй, 2019 онд гэрээ байгуулаагүй байна.

Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “ЗГ-ын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих ТАХ-г хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 10.1.26-д төсөл хэрэгжиж дууссаны дараа төслийн үр нөлөөний үнэлгээг хараат бус мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн, тайланг Удирдлагын мэдээллийн системд оруулахаар заасан боловч үнэлгээ хийлгэж мэдээлсэн

зүйлгүй байна. Энэ нь засаг захиргааны дээд байгууллагын шийдвэр хэрэгжихгүй байх, хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнгийн талаар иргэд олон нийтэд мэдээлэл хомсдох үр дагавартай байгаад дүгнэлт хийж ажиллах нь шаардлагатай байна.



БҮЛЭГ Б. Хөдөө аж, ахуйн салбарт хэрэгжүүлсэн тусламж олон нийтийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа боловч зарим хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Б.1.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь урт, дунд, богино хугацааны бодлогыг дэмжиж байна.

Дундговь аймгийн хэмжээнд Хөдөө аж ахуйг дэмжих зорилгоор Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Нэгдсэн үндэсний байгууллагын хөдөө аж ахуйн байгууллага, Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн санхүүжилтээр нийт 6,421.5 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүд Аймгийн Засаг даргын 2020-2024 онд үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан-3, аймгийг хөгжүүлэх 2020-2025 оны үндсэн чиглэлд тусгагдсан-3 зорилтуудыг дэмжсэн байна.

Б.1.2. Аймгийн хэмжээнд хөдөө аж, ахуйн салбарт хэрэгжсэн тусламж нь тус салбарт шаардлагатай хөрөнгүүд нийлүүлэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд хөдөө аж, ахуйн салбарт хэрэгжсэн тусламжууд тус салбарын хэрэгцээ шаардлагыг хангаж байна. Үүнд:

1. Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн санхүүжилтээр 2019-2023 онд хэрэгжүүлсэн 2,975.7 сая төгрөгийн төсөл арга хэмжээ нь бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэхэд Цагаандэлгэр сумаас бусад сумдад 40 худаг, ган, зудтай үед өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх, түүнийг хадгалж хамгаалахад Эрдэнэдалай, Баянжаргалан, Сайнцагаан сумдад 4-н өвс тэжээлийн агуулах, малын халдварт өвчлөөс урьдчилан сэргийлэхэд зориулж Луус, Дэлгэрхангай сумаас бусад сумдад 26 угаалгын ванн, бэлчээрийн доройтлоос хамгаалахад огтоно устгалын 30 тоног төхөөрөмж, хүнсний ногоо хадгалах зоорь зэрэгт зориулагдсан байна.
2. Азийн хөгжлийн банкны тэжээлийн тогтвортой менежмент төслийн хүрээнд Луус суманд тэжээлийн ургамал тариалах сургалт зохион байгуулж 5.8 сая төгрөгийн үрээр хангаж, ХХААГ-т 78.0 сая төгрөгийн 50 морины хүчтэй трактор дагалдах хэрэгслүүд, шинэ компьютер олгосон байна. Мөн тус банкны санхүүжилтээр Баянжаргалан, Гурвансайхан, Дэлгэрхангай, Өлзийт, Өндөршил сумдад 130.0 сая төгрөгийн инженерийн хийцтэй 5 худгийг гаргасан байна.
3. Шинэ хөдөө төслийн хүрээнд газар тариалангийн чиглэлээр 297.7 сая төгрөгийн Баянжаргалан, Сайнцагаан сумдад трактор дагалдах хэрэгсэл, мөн дээрх 2 сум болон бусад сумдад хүлэмж дагалдах хэрэгслүүд, 704.0 сая төгрөгийн ноос хяргах төхөөрөмж, явуулын пункт, ванныг нийлүүлэх гэрээ байгуулж 642.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна. Энэ төслөөр Луус суманд тэжээлийн ургамал тариалах зориулалтаар 50 морины хүчтэй трактор, анжисны хамт хуваариалан олгосон байна.

4. Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн хүрээнд орон нутагт ажиллаж байгаа хувийн малын эмч нарт зориулсан багц цагийн сургалтыг 6.1 сая төгрөгөөр зохион байгуулсан байна. Энэхүү сургалт нь малын эмч нарыг чадавхижуулах, мал эмнэлгийн хүний нөөцийн хөгжил удирдлагын системийг нэвтрүүлэх зорилготой бөгөөл малын эмч, мэргэжилтэнд зориулсан сургалт, мэдээллүүд уг системээр дамжин хүргэх нөхцөл бүрдүүлэхэд чиглэгдсэн байна. Мөн 420 малчныг сургалтад хамруулсан нь малчид өөрийн мал сүргийг халдвараас хамгаалах мэдлэг, дадалтай болохоос гадна халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлж мал эмнэлгийн байгууллагад шуурхай мэдээлэх чадвартай болсны зэрэгцээгээр мал эмнэлгийн үйлчилгээний ач холбогдлыг бүрэн ойлгож, мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээнд малаа бүрэн хамруулдаг болох ойлголтыг бий болгосон байна. Тус төслийн хүрээнд ган зудын хохирлыг бууруулах зорилгоор 2,174.4 тн савлагаатай хүчит тэжээлийн дэмжлэгийг тус үзүүлсэн байна.

Хэдийгээр дээрх төсөл арга хэмжээнүүдийн үр дүнд хөдөө аж ахуйн салбарт хэрэгцээ шаардлагатай хөрөнгүүд бий болсон боловч зарим хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна. Тухайлбал: Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн 119.0 сая төгрөгийн санхүүжилттэй хүнсний ногооны зоорь, Шинэ хөдөө төслийн 49.9 сая төгрөгийн тэжээлийн ургамал тариалах тракторыг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Энэ нь төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хөрөнгүүд зориулалтын дагуу ашиглагдахгүй, үрэгдэн шамшигдах, хадгалалт хамгаалалтгүй болох эрсдлийг бий болгож байна.

Иймд дээрх хөрөнгүүдийг зориулалтын дагуу ашиглаж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Б.2.1. Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн хугацаа 56 хоногоор хэтэрсэн байна.

Шинэ хөдөө төслийн хүрээнд хэрэгжсэн 704.0 сая төгрөгийн ноос хяргах төхөөрөмж, явуулын пункт, ванныг нийлүүлэх “Сорьц хаус” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай байгуулсан гэрээ 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөр дуусгавар болсон байхад 62.0 сая төгрөгийн ноос пресслэгч-5, цахилгааны эх үүсвэр мотор-5, ирлэгч-5, ноос хяргах хайчны хоёр төрлийн 250 хос ирийг үний өсөлттэй холбоотой алдагдал хүлээж байгаа шалтгаанаар одоогийн байдлаар нийлүүлээгүй байна. Тус компанитай 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн ХХААҮЯ202212038 дугаар бүхий ажил гүйцэтгэх гэрээнд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг техникийн үзүүлэлтийн дагуу гэрээт хугацаанд хүлээлгэн өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй ба үний дүнгийн 0.3 хувиар алданги ногдуулна гэж зааснын дагуу тооцоход 10.4 сая төгрөгийн алданги тооцогдохоор байна. Дээрх төслийн хүрээнд нийлүүлэгдсэн зарим тоног төхөөмжүүдийг Хүнс хөдөө аж ахуйн хашаанд ил задгай хадгалж байгаа нь хадгалалтын горим шаардлагыг хангахгүй байна.

Б.2.2. Гэрээний биелэлтийг дүгнэж, хэрэгжилтийг тооцоогүй байна.

Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжсэн тусалмжийн талаар үр дүн, үр нөлөөллийг тооцсон судалгаа, шинжилгээгүй хийгдээгүй байна. Аймгийн хэмжээнд хөдөө аж ахуйн салбарт хэрэгжсэн төсөл арга хэмжээний гэрээг дүгнэж, үр дүн, үр нөлөөг тооцсон баримт

материалыг ирүүлээгүй зэрэг нь тус төсөл арга хэмжээний гэрээний биелэлт, үр дүн тооцоогүй гэж дүгнэхээр байна.

Иймд төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, гэрээний биелэлтийг дүгнэж, үр дүн, үр нөлөөг тооцож, дутуу нийлүүлэгдсэн хөрөнгийг бүрэн хүлээн авах талаар хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах шаардлагатай байна.

БҮЛЭГ В. Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавьсан ч, бүрэн баримтжуулаагүй, санхүүгийн бүртгэл зөрүүтэй байна.

В 1. Зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавих хяналт үр дүнтэй байна.

Судалгаагаар аймгийн хэмжээнд ХАА-н салбарт 2019-2023 онуудад олгосон нийт 6,421.5 сая төгрөгийн тусламжийн ихэнхийг нь “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төсөл 2,975.7 сая төгрөг буюу 46.3 хувийг, Дэлхийн банкны “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл 2,174.4 сая төгрөг буюу 33.8 хувийг тус тус эзэлж байна. Үүнээс “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн тусламжид хамрагдсан хамгийн их тоо хэмжээгээр Эрдэнэдалай 48 буюу 27.3 хувь, Сайхан-Овоо 40 буюу 22.7 хувь, Дэлгэрцогт сум 34 ажил хийгдэж 19.3 хувийг тус тус эзэлж байна. Харин мөнгөн дүнгээр авч үзвэл 1,332.2 сая төгрөгийг Сайнцагаан сум авсан нь нийт тусламжийн 44.8 хувь байна. Энэ нь Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Дэлгэрцогт сумдад оготно устгах төхөөрөмж олгож, худгийн засвар, ажлын байрны засвар хийгдэж, эрсдэлийн сан байгуулж, малчдын сургалт мэдээллийн төв тохижуулах ажлууд хийгдсэнтэй, Сайнцагаан суманд хүнсний ногооны зоорь, мал үржлийн багаж тоног төхөөрөмж, борлуулалтын цэгийн дэмжлэг авсан, агуулах, шинээр барьсан борлуулалтын цэгийн санхүүжилтээр тус тус илүү байгаатай холбоотой байна.

Хүснэгт №2

№	Сумын нэр	нийт дүн		Нийт дүнд эзлэх хувь
		Тоо хэмжээ	Мөнгөн дүн	
1	Эрдэнэдалай	48	385.1	12.9
2	Сайхан-овоо	40	219.8	7.4
3	Дэлгэрцогт	34	189.0	6.4
4	Дэрэн	3	52.0	1.7
5	Луус	3	44.8	1.5
6	Хулд	4	95.6	3.2
7	Баянжаргалан	3	143.4	4.8
8	Говь-Угтаал	5	96.4	3.2
9	Гурвансайхан	5	103.4	3.5
10	Сайнцагаан	13	1332.2	44.8
11	Цагаандэлгэр	2	30.0	1.0
12	Адаацаг	3	59.0	2.0
13	Өндөршил	4	72.8	2.4
14	Өлзийт	6	123.7	4.2
15	Дэлгэрхангай	3	28.5	1.0
	дүн	176	2,975.7	100

В.1.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээнд эрх бүхий байгууллагууд хяналт тавьсан ч бүрэн баримтжуулаагүй байна.

Аймгийн ХАА-н салбарт 2019-2023 онуудад Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил, Дэлхийн банкны МААЭЗ-ийн эргэлтийг нэмэгдүүлэх, Азийн хөгжлийн банкны санхүүжилт, Азийн хөгжлийн банкны тэжээлийн тогтвортой менежмент, Шинэ хөдөө төсөл зэргээс тусламжийг санхүүжүүлжээ. Үүнээс Шинэ хөдөө төслөөс хэрэгжүүлсэн 1,001.7 сая төгрөгийн арга хэмжээний баримт материалыг аудитын явцад ирүүлсэнгүй. “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн тусламжаар хэрэгжүүлсэн 13 төрлийн арга хэмжээнээс:

- Өвс тэжээлийн агуулах шинээр барих;
- Бог малын угаалгын ванн;
- Ажлын байр засварлах
- Өвс тэжээлийн агуулах засварлах /Дэлгэрцогт сум/
- Борлуулалтын цэг шинээр барих ажлууд захиалагч болон зохиогчийн хяналтыг хийж гэрээг дүгнэн баримтжуулсан байна.

Харин Өндөршил, Өлзийт сумдад хийсэн бог малын угаалгын ванн хийх ажилд захиалагчийн хяналт хийгээгүй, Дэлгэрцогт суманд өвс тэжээлийн агуулах засварлах, борлуулалтын цэг шинээр барих ажлыг хүлээн авахдаа гэрээ дүгнэсэн акт үйлдэж баримтжуулаагүй байна.

Иймд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг захиалагчийн хяналтыг бүрэн хийж тайлан бичиж хэвших, гүйцэтгэгчээс хүлээн авахдаа гэрээний үүргийн биелэлтийг тооцож, акт үйлдэн баримтжуулж хэвших нь зүйтэй.

В.2. Зээл, тусламжийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцоогүй байна.

В.2.1. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.

Тусламжийн арга хэмжээг гүйцэтгэсэн ажлын нэр төрлөөр авч үзвэл “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн 31.4 хувь буюу 934.3 сая төгрөгийг худаг гаргахад, 27.6 хувь буюу 820.9 сая төгрөгийг өвс тэжээлийн агуулах барихад, 12.9 хувь буюу 382.6 сая төгрөгийг борлуулалтын цэг шинээр барихад тус тус зарцуулжээ.

Хүснэгт №3

№	Үзүүлэлт	Тоо хэмжээ	Мөнгөн дүн	Нийт дүнд эзлэх хувь
1	Худаг	40	934.3	31.4
2	Агуулах	6	820.9	27.6
3	бог мал угаалгын ванн	26	331.9	11.2
4	Оготно устгах тоног төхөөрөмж	60	23.3	0.8
5	БАМБ-ийн худаг засвар	28	14	0.5
6	Ажлын байр засварлах	4	149.5	5.0
7	Хүнсний ногооны зоорь	1	119	4.0
8	Агуулах засварлах	1	71.5	2.4
9	Борлуулалтын цэг шинээр барих	2	382.6	12.9
10	Мал үржлийн багаж тоног төхөөрөмж	1	35.9	1.2
11	Малчдын сургалт мэдээллийн төв тохижуулах	3	12.9	0.4
12	Эрсдэлийн сан	3	60	2.0

13	Борлуулалтын цэгийн дэмжлэг	1	19.8	0.7
	Нэгдсэн дүн	176	2,975.7	100

Харин хүртээмжийн хувьд худаг Цагаандэлгэрээс бусад сумдад буюу 93.3 хувийг, бог малын угаалгын ванн Луус, Хулд, Дэлгэрхангайгаас бусад сумдад буюу 80.0 хувийг хамарчээ.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөө, хэрэгжилт болон Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайланд аудитад хамрагдсан хугацааны хөдөө аж ахуйн салбарт олгосон зээл тусламжийн хэрэгжилтийн талаар үнэлгээ хийсэн мэдээлэл байхгүй байна. Харин аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл төлөвлөгөөний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд мал угаалгын 26 ванн ашиглалтанд оруулж зорилтот түвшиндээ хүрсэн гэж дүгнэн ажлын гүйцэтгэлийг 100 хувиар үнэлсэн байна.

В.2.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний бүртгэл зөрүүтэй байна.

2019-2023 онуудад Дундговь аймгийн Хөдөө аж ахуйн салбарт нийт 110.0 сая төгрөгийн зээл, 6,421.5 сая төгрөгийн тусламж олгогдсон байна. Төслийн хүрээнд олгогдсон тусламжийн 3,861.6 сая төгрөг буюу 60.1 хувь нь хөрөнгийн чанартай тоног төхөөрөмж, эд зүйл байна. Аудитын явцад тусламжийн хөрөнгийн бүртгэлийг сумдын холбогдох байгууллагын бүртгэлтэй түүвэрлэн тулган шалгалаа. Тулгалтаар “Зах зээл бэлчээрийн удирдлага хөгжил” төслийн тусламжаар хийгдсэн ажил аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс ирүүлсэн судалгааны дүн нь холбогдох байгууллагуудын санхүүгийн тайланд бүртгэсэн дүнгээс нийт 22.6 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Тус зөрүү нь судалгаанаас 15.1 сая төгрөгөөр илүү, 7.4 саяар дутуу, тухайлбал Гурвансайхан суманд оготно устгах 5.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж судалгааны дүнд ороогүй, Луус, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Адаацаг сумдад хийгдсэн худаг, бог малын угаалгын ванн 1.7-4.5 сая төгрөгийн зөрүүтэй байгаатай холбоотой байна.

Мөн Баянжаргалан, Гурвансайхан, Дэлгэрхангай, Өлзийт, Өндөршил сумдад Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийсэн инженерийн хийцтэй худаг нийт дүнгээрээ 4.6 сая төгрөгийн зөрүүтэй, Луус суманд 2022 онд ирсэн хүлэмж, 2023 онд трактор, анжис анхан шатны баримтгүй үнэ тодорхойгүй тул орлогодож аваагүй байна.

Шинэ хөдөө төслийн хүрээнд хүлээн авсан үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байсан тул “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар зөрчлийг арилгуулах 199.9 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хөрөнгийг бүрэн авсны дараа бүртгэлд тусгана гэсэн хариуг ирүүлсэн болно.

Аудитад ирүүлсэн судалгааны дүн алдаатай, мэдээлэл зөрүүтэй аудитын явцад олон дахин өөрчлөгдөж байсан нь нөхцөл байдлыг үнэн зөв тодорхойлж дүгнэлт өгөхөд хүндрэл үүсгэж байлаа. Иймд бүртгэл судалгааны үнийн зөрүүний шалтгааныг тогтоож бүртгэл тайланд залруулах, анхан шатны баримт дутуугаас бүртгэлд тусгаагүй хөрөнгийн баримтыг бүрдүүлж бүртгэл тайланд тусгах, цаашид тайлангийн хугацаанд тооцоо нийлж бүртгэлийн үнэн зөв байдлыг хангаж, холбогдох байгууллага, хэлтэс агентлагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, хариуцлагатай ажиллах шаардлагатай байна.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- ✓ Зээлийн хөрөнгийг ашиглагч гэрээнд заасан үүргээ тогтоосон хугацаанд бүрэн биелүүлсэн байна.
- ✓ Хөдөө аж, ахуйн салбарт эхрэгжүүлсэн тусламж олон нийтийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа боловч зарим хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, үр дүнг тооцож ажиллаагүй байна.
- ✓ Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй байна.
- ✓ Төсөл хөтөлбөрийн хүрээнд бий болсон хөрөнгийг тайлангийн хугацаанд тооцоо нийлж бүртгэлийн үнэн зөв байдлыг хангаж, холбогдох байгууллага, хэлтэс агентлагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, хариуцлагатай ажиллах шаардлагатай байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг бүрэн тусгаж хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж үр дүнг тооцож ажиллах;
2. Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, гэрээний биелэлтийг дүгнэж, дутуу нийлүүлэгдсэн хөрөнгийг бүрэн хүлээн авах талаар хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах;
3. Бүртгэл судалгааны үнийн зөрүүний шалтгааныг тогтоож бүртгэл тайланд залруулах, анхан шатны баримт дутуугаас бүртгэлд тусгаагүй хөрөнгийн баримтыг бүрдүүлж бүртгэл тайланд тусгаж, тайлангийн хугацаанд тооцоо нийлж бүртгэлийн үнэн зөв байдлыг хангаж, холбогдох байгууллага, хэлтэс агентлагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж ажиллах;



Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Засаг даргад танилцуулж санал тайлбарыг авлаа.



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын
ордон, 7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас/факс: 70592353 Цахим шуудан: info@dundgovi.gov.mn
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2023. 08. 14 № 01/1073
танай _____ -ны № _____ -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн
хөрөнгийн ашиглалт, үр өгөөж-д хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Санал
тайлбар байхгүй болно.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4824130821

Дундговь аймгийн Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээл тусламжийн хөрөнгийн судалгаа															
№	Төсөл арга хэмжээний нэр	Зориулалт	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Санхүүжилт /мянган төгрөгөөр/					Нийт дүн	Төсөл арга хэмжээний гүйцэтгэл хувиар				Төсөл арга хэмжээ хэрэгжсэн сум, байгууллага	Тайлбар
				2019	2020 он	2021 он	2022 он	2023 он		2020 он	2021 он	2022 он	2023 он		
	A	1	2		3	4	5	6		7	8	9	10	12	15
1	Дэлхийн банкны МАА-ЭЗЭН төсөл	Малчдад тусламжийн тэжээл тараасан	Дэлхийн банк		-	2,174.4	-	-	2,174.4		100			15 сум	Савлагаатай хүчит тэжээлийн дэмжлэг үзүүлсэн
2	Азийн хөгжлийн банкны тэжээлийн тогтвортой менежмент төсөл	Тэжээлийн ургамал тариалах,Трактор, компьютер хүлээн авсан	АХБанк		-	-	5.8	78.0	83.8			100	100	Луус сум	Луус суманд тэжээлийн ургамал тариалах сургалт зохион байгуулж үрээр хангасан, ХХААГ-т 50 морьны хүчтэй трактор дагалдах хэрэгслүүд, шинэ компьютер олгосон.
3	Азийн хөгжлийн банкны санхүүжилт	Инженерийн хийцтэй худаг гаргах	АХБанк		130.0	-	-	-	130.0	100				Баянжаргалан Гурвансайхан Дэлгэрхангай Өлзийт Өндөршил	Баянжаргалан, Гурвансайхан, Дэлгэрхангай, Өлзийт, Өндөршил сумдад инженерийн хийцтэй 5 худаг гаргасан.
4	Шинэ хөдөө төсөл 2022-2023	Ноос хяргах төхөөрөмж, явуулын пункт, угаалгын ванн нийлүүлэх			-	-	704.0	-	704.0			91.2			62.0 сая төгрөгийн тоног, төхөөрөмж хугацаандаа нийлүүлэгдээгүй.
5	ХХААХҮЯ Шинэ хөдөө төсөл	Тэжээлийн ургамал нийлүүлэх, трактор, анжис нийлүүлэх	Шинэ хөдөө төсөл		-	-	49.9	-	49.9			100		Луус сум	Тэжээлийн ургамал тариалах зориулалтаар Луус суманд 50 морьны хүчтэй трактор, анжисны хамт хуваарилан олгосон.

6	Шинэ хөдөө төсөл 2022	Газар тариалангийн чиглэлээр 15 нэр төрлийн тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэх	Шинэ хөдөө төсөл		-	-	297.7	-	297.7			100		15 суманд	Баянжаргалан, Сайнцагаан сумдад трактор дагалдах хэрэгсэл, мөн дээрх 2 сум болон бусад сумдад хүлэмж дагалдах хэрэгслүүд олгсон.
7	НҮБ-ын ХААБ-ын санхүүжилтээр	Малчдад тусламж олгох	НҮБ-ХААБ		-	-	-	-	-		100		Адаацаг, Дэлгэрхангай, Дэрэн, Дэлгэрцогт, Өлзийт, Хулд, Сайнцагаан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай	300-буюу түүнээс доош толгой малтай эмзэг бүлгийн өрх толгойлсон 144 малчин өрхөд уургаар баялаг рапсын шахдас, хорголжин тэжээл, малын сувилалын багцыг олгосон. /Мөнгөн дүн,жагсаалт олдоогүй/	
8	Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ	Төсөлд хамрагдсан аймаг, сумдын малчид болон орлого багатай иргэдийн ядуурлыг бууруулж амьжиргааг дээшлүүлэх явдал юм.	НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан	352.6	999.3	955.6	674.2		2,981.7	100	100	100	100	Бүх сумд	
	Нийт дүн			352.6	1,129.3	3,130.0	1,731.6	78.0	6,421.5						

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ОН